



“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ”ХК

“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК-Д УУРХАЙН ЗАХИРГААНЫ БАРИЛГАД
ХАЛААЛТЫН ЗУУХ УГСРАХ, ХАЛУУН ХӨШИГ ТАВИХ АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОХ ҮНИЙН САНАЛ АВАХ
БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын дугаар

ЭТТ/201901009

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Уурхайн захиргааны барилгад халаалтын зуух угсрах, халуун хөшиг тавих ажлыг” гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 09 цаг 00** минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 09 цаг 10** минутад нээнэ.

Тендер хүлээн авах этгээд: Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.

Дотоодны давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Финанс төв, 5 давхар 503 тоот, Жигжиджавын-8,
Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Улаанбаатар хот, Монгол улс
Утас:75055555, Дотуур утас 507**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын**

5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**хүчинтэй
байх хугацаа**

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт																														
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогчдын эрх бүхий болон гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлоход дараах материалыг ирүүлэх шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ. 2. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягтын дагуу гаргаж ирүүлнэ. 3. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдөр Цахим тендерийн журмын 4.1.9-ийг үндэслэн www.tender.gov.mn цахим хуудасны лавлагаа хэсгээс шалгахад бүрэн төлсөн байх. Татварын цахим тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй. 4. Харьяа нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт ирүүлнэ. /Тендер зарласан өдрөөс хойших байдлаар байна./ 5. Иргэний хэргийн шүүхийн тодорхойлолт ирүүлнэ. /Тендер зарласан өдрөөс хойших байдлаар байна./ 6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлнэ. /Тендер зарласан өдрөөс хойших байдлаар байна./ 7. Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолт ирүүлнэ. /Тендер зарласан өдрөөс хойших байдлаар байна./ 8. Сүүлийн 2 жилийн /2017, 2018 он/ борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх. 9. Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай инженер техникийн ажилтан: <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse; margin-top: 10px;"> <thead> <tr> <th style="width: 5%;">№</th> <th style="width: 25%;">Албан тушаал</th> <th style="width: 10%;">Хүний тоо</th> <th style="width: 20%;">Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага</th> <th style="width: 40%;">Мэргэжил</th> </tr> </thead> <tbody> <tr> <td style="text-align: center;">1</td> <td>Төслийн ахлагч</td> <td style="text-align: center;">1</td> <td>3 болон түүнээс дээш жил</td> <td>Цахилгааны инженер</td> </tr> <tr> <td style="text-align: center;">2</td> <td>Барилгын инженер</td> <td style="text-align: center;">1</td> <td>2 болон түүнээс дээш</td> <td>Барилгын инженер</td> </tr> <tr> <td style="text-align: center;">3</td> <td>Дулааны инженер</td> <td style="text-align: center;">1</td> <td>2 болон түүнээс дээш</td> <td>Дулааны инженер</td> </tr> <tr> <td style="text-align: center;">4</td> <td>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан</td> <td style="text-align: center;">1</td> <td>1 болон түүнээс дээш жил</td> <td>/ХАБЭА сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх/</td> </tr> <tr> <td style="text-align: center;">5</td> <td>Мэргэжилтэй ажилчид</td> <td style="text-align: center;">4</td> <td>1 болон түүнээс дээш жил</td> <td>Шаардлагатай мэргэжлийн гэрчилгээ авсан байх</td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> - Инженер техникийн ажилчдын жагсаалтыг МАЯГТ №ТШМ-2-д заасны дагуу бөглөж ирүүлнэ. - Дээрх инженер техникийн ажилтнуудын сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар, гэрчилгээний хуулбар, иргэний үнэмлэхний хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ. - Төслийн ахлагч, Барилгын инженер, Дулааны инженер, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нар нь тухайн байгууллагын үндсэн ажилтнууд байх ба нийгмийн даатгалын хэлтсээс 	№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил	1	Төслийн ахлагч	1	3 болон түүнээс дээш жил	Цахилгааны инженер	2	Барилгын инженер	1	2 болон түүнээс дээш	Барилгын инженер	3	Дулааны инженер	1	2 болон түүнээс дээш	Дулааны инженер	4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил	/ХАБЭА сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх/	5	Мэргэжилтэй ажилчид	4	1 болон түүнээс дээш жил	Шаардлагатай мэргэжлийн гэрчилгээ авсан байх
№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил																											
1	Төслийн ахлагч	1	3 болон түүнээс дээш жил	Цахилгааны инженер																											
2	Барилгын инженер	1	2 болон түүнээс дээш	Барилгын инженер																											
3	Дулааны инженер	1	2 болон түүнээс дээш	Дулааны инженер																											
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил	/ХАБЭА сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх/																											
5	Мэргэжилтэй ажилчид	4	1 болон түүнээс дээш жил	Шаардлагатай мэргэжлийн гэрчилгээ авсан байх																											

	<p>баталгаажуулсан НД-8 маягтыг сүүлийн 6 сарын байдлаар хавсарган ирүүлнэ. /НД-8 маягтаас тухайн байгууллагын үндсэн ажилтан мөн эсэхийг хянан үзнэ/хэсгийн хуулбарыг ирүүлнэ.</p> <p>- Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалтыг МАЯГТ №ТШМ-6-д заасны дагуу бөглөж ирүүлнэ.</p>
төсТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсэг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Огноо: 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Цаг: 09 цаг 00 минут</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байшин, гудамжны нэр: Финанс төв, 5 давхар 503 тоот, Жигжиджавын-8, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Улаанбаатар хот, Монгол улс Утас:75055555, Дотуур утас 507 Худалдан авалт, ханган нийлүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Д.Бодьцэцэг</p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр. Цаг: 09 цаг 10 минут.</p>
ТӨӨЗ 3.1	<p>Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үнийн саналыг маягтын дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ. 2. Үе шатны ажлын хуваарийг баталгаажуулан ирүүлнэ. 3. Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны хуваарийг баталгаажуулан ирүүлнэ. 4. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ. 5. Сүүлийн 2 жил /2017, 2018 он/ тус бүр тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх. Ижил төстэй ажилд халаалтын цахилгаан зуух угсарч суурилуулсан ажлыг тооцно. /Ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, улсын комисс хүлээж авсан актын хуулбар, тухайн ажлыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн тухай захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ/. 6. Тендерт оролцогч тухайн барааг нийлүүлэхэд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Эрчим хүчний яамнаас олгодог (03.3.3,03.5.3), (03.2.1-03.2.4) - Барилга хот байгуулалтын яамны (БА-8.1) 7. Төсвийг зураг, ажлын тоо хэмжээний дагуу тооцож эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулж ирүүлнэ. БХБСайдын 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 185-р тушаалын дагуу зохиогчийн хяналтын зардлыг үнийг тооцож ирүүлнэ. Магадлашгүй ажлын зардал, норм нормативийн сангийн зардлыг төсөв зохиох зааврын дагуу, татвар хураамжийг холбогдох хуульд нийцүүлэн тус тус тооцож ирүүлнэ. Захиалагч байгууллагаас зураг төсвийн үнийг тендерийн үнийн саналд тусгуулахаар заасан тохиолдолд төсөвт тооцож ирүүлнэ. Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэнэ. Үнийн хөнгөлөлт тооцсон тохиолдолд задаргаа болон үндэслэлийн хамт ирүүлнэ.

	<p>Төсөвт арифметик алдаа болон орхигдуулсан жижиг хэмжээний зөрүүг залруулах, үнийн хөнгөлөлтийг харгалзан тендерийн үнийг бууруулах, давуу эрх эдлэх этгээдийн хувь хэмжээг тооцож, үнэлгээний бусад шалгуур үзүүлэлтийг сонгосон бол тэдгээрт харгалзах саналуудыг мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэ дээр харгалзан тооцож тендерийн харьцуулах үнийг тодорхойлно. Их хэмжээний зөрүүтэй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно</p> <p>8. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэгийг ирүүлнэ.</p> <p>9. Шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүн, ажил гүйцэтгэх үе шатны хуваарьт багтаан ажлыг чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөх тухай баталгааг албан бичгээр ирүүлнэ.</p> <p>10. Татвар, нийгмийн даатгал, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлнэ.</p> <p>Дээр заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 4.1	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахгүй тогтмол байна.
ТӨӨЗ 6.1	Тендер нээснээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй.

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Техникийн тодорхойлолтыг бэлтгэх санамж

Товч бөгөөд тодорхой бэлтгэгдсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.

Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ өрсөлдөөнийг аль болох өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд үүний зэрэгцээ худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн, эсхүл орчин үеийн загварын, зураг төсөл, материалын хувьд сүүлийн үеийн хандлагыг хангасан байх нөхцөлийг техникийн тодорхойлолтод шаардах ёстой.

Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай байдаг. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ метрийн системийг ашиглана. Бүх салбарт хэрэглэж болох нийтлэг жишиг техникийн тодорхойлолт гэж байхгүй. Бүх төрлийн бараа, ажлын стандарт буюу ерөнхий техникийн тодорхойлолт боловсруулж стандартчилах нь чухал ач холбогдолтой. Энэ стандарт техникийн тодорхойлолтыг тухайн ижил бараанд нийцүүлэн, зохих өөрчлөлт оруулах замаар ашиглана.

Авто зам, усан зогсоол, төмөр зам, орон сууц, усжуулалт, усан хангамж гэх зэрэг дэд бүтцийн салбаруудад тухайн бүс нутгийн ижил төстэй нөхцөлд давтагдаж хийгдэх ажлуудад стандарт ерөнхий техникийн тодорхойлолтыг хэрэглэх нь ихээхэн давуу талтай. Хэдийгээр тухайлсан ажлын гэрээнд заавал хэрэглэх шаардлагагүй хэдий ч барилгын ажилд хамаарах онцлог шинж чанар, материал, тоног төхөөрөмжийн бүх ангиллыг ерөнхий техникийн тодорхойлолтод тусгах шаардлагатай. Тухайн ажлын техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ ерөнхий техникийн тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт хийх буюу шаардлагагүй зүйлийг түүнээс хасна.

Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Бараа, материал, шинж чанарын талаарх техникийн тодорхойлолтын стандартад аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа, материал, шинж чанар нь энэ стандартыг хангах буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй. Дараах заалтыг гэрээний тусгай нөхцөлд, эсхүл техникийн тодорхойлолтод тусгаж болно.

Жишиг заалт: Стандарт болон кодын дүйцэх байдал

Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал болон хийгдэх, эсхүл турших ажлын стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсноор хэрэглэнэ.

Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй жишихүйц, эсхүл түүнээс илүү чанартай бусад стандарт, кодыг төслийн менежер хянаж, бичгээр зөвшөөрөл олгосон бол хүлээн зөвшөөрнө.

Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд зориулсан эдгээр санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулах шаардлагагүй.

**УУРХАЙН ЗАХИРГААНЫ БАРИЛГАД ХАЛААЛТЫН ЦАХИЛГААН
ЗУУХ УГСРАХ, ХАЛУУН ХӨШИГ ТАВИХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. Үндэслэл	“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө
2. Байршил	Өмнөговь аймаг Цогтцэций сум
3. Зориулалт	Уурхайн захиргааны барилгыг дулаанаар хангах, засварын газрын заалны хаалганд халуун хөшиг тавих
4. Ажлын бүрэлхүүн	I. Халаалтын цахилгаан тогоо суурилуулах,узелийн өрөөны дулааны зангилааг бүрэн шинэчлэх ,буцах шугамыг 130 м хэсэгт шинээр солих дулаалага 130 м хэсэгт хийх , хуучин халаалтын тогоо, яндан бусад зүйлсийг зайлуулах, II. Засварын газрын 7,5x7,4м 5,4x4,2м хэмжээтэй 2 хаалганд халуун хөшиг тавих III.Халаалтын тогоо, халуун хөшигнүүдийн цахилгааны тэжээлийн кабель, ерөнхий самбар, тоноглолуудын холболтын кабель монтажлах IV. Узелийн өрөөнд барилгын засвар хийх.
5. Барилга байгууламжийн зориулалт, хүчин чадал	<ul style="list-style-type: none"> - 1000-1500 м2 5400 м3 эзэлхүүнтэй барилгыг халаах халаалтын цахилгаан зуухыг тус байрны узелийн өрөөнд угсрах /60 кВт 2ш тогоо/ Узелийн өрөөний дулааны зангилгааг бүрэн шинэчлэх - Халуун хөшиг тавих хаалганы хэмжээ 7,5м x 7,4м ; 5,4м x4,2м 2 хаалга
6. Ажил гүйцэтгэх хугацаа	45 хоног
7. Гүйцэтгэгч байгууллага	ЭХЯ-наас олгодог (03.3.3 ,03.5.3) ; (03.2.1-3.2.4) БХБЯ-ны(БА-8.1) тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллага байна.
8. Халаалтын зуух, халуун хөшгөнд тавигдах ерөнхий шаардлага	<ul style="list-style-type: none"> - Засварын газрын 7,5x7,4м 5,4x4,2м хэмжээтэй хоёр хаалганд цахилгаан халуун хөшиг суурилуулах.Халуун хөшигний хүчин чадал тоо ширхэгийг тухайн хаалгануудын хэмжээнд тохируулан тооцох. - Халуун хөшиг хаалганы дээр байрлуулахаар тооцно. - Дээрхи үзүүлэлтийг хангасан техникийн паспорт, тооцоо, холбогдох норм дүрмийн дагуу боловсруулан тендерийн материалд хавсаргах.
9. Халаалтын тогоо, узелийн зангилаа шугам хоолой, насос ба хаалт винтельд тавигдах шаардлага	<p>Халаалтын тогоо нь: ДАКОН халаалтын цахилгаан зуухтай дүйцэх дараах үзүүлэлтийг хангасан байна. Тохирлын гэрчилгээг ирүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Бүрэн автомат ажиллагаатай Тохируулагч болон сэргийлэх хамгаалалттай 3 шатлалт тохируулга (50%, 75%, 100% тавилтууд) - Өөрийгөө хамгаалах систем (Даралт ихсэх, буух тохиолдолд автоматаар унтарна. Задрах, дэлбэрэх аюулгүй.) - Эрчим хүчний хэмнэлттэй - Өөр дээрээ аваарын клапан болон хий авагчтай <p>Халаалтын буцах шугам:</p>

	<ul style="list-style-type: none"> - Халаалтын буцах усны шугам хоолойн дулаалга хийх дулаалгын материал нь стандартын шаардлагад нийцсэн дулаалгын материалыг хэрэглэх. /130 м / - Халаалтын эргэлтийн насос тэлэлтийн савыг халаалтын системд тохируулан тооцож сонгон авч угсрах. - Халаалтын системийн дулаан зөөгч, дүүргэлтийн шингэнийг зориулалтын хөлдөхгүй шингэнээр дүүргэн туршиж, шалган хүлээлгэн өгөх. Халуун хөшиг: - Халуун хөшиг нь дуу чимээ багатай, халуун агаарын урсгалыг тохируулах тохиргоотой, алсын удирдлагатай, цахилгааны зарцуулалт багатай, эрчим хүчний хэмнэлттэй байна.
<p>10.Цахилгааны хуваарилах самбар, холболтын кабель, цахилгааны тоног төхөөрөмжинд тавигдах шаардлага</p>	<p>Цахилгааны нийт хэрэглээ 130 кВт</p> <ul style="list-style-type: none"> - Цахилгааны ерөнхий самбар нь /1000x800x300/ мм хэмжээтэй байна.Оролтын болон гаргалгааны автоматуудыг ачаалалд тохируулан тооцоогоор сонгоно. Ерөнхий хуваарилах самбарт цэнэг шавхагч, цахилгаан эрчим хүчний тоолуур тавина. Цахилгааны ерөнхий самбарт газардуулах байгууламж хийх - Цахилгааны эх үүсгэвэрээс ерөнхий хуваарилах самбарт очих тэжээлийн кабелийг АВВГ-3х120+1х70 маркийн кабель байхаар сонгоно. Урт 100 м - Барилгын ханыг цоолж кабель сүвлэхдээ зориулалтын ган булан хоолой ашиглана. - Халаалтын тогооны удирдлагын самбар хүртэл 15 м кабель татна. - Халуун хөшигнүүд зориулсан хуваарилах самбарыг засварын газрын зааланд байрлуулна. Ерөнхий хуваарилах самбараас халуун хөшигнүүдийг тэжээх хуваарилах самбар хүртэл 45 м АВВГ-3х25+1х10 кабель барилгын хананд бэхлэн татаж холбоно. - Халуун хөшигнүүдийг тус тусад нь холбох ба хэт ачаалал болон богино залгааны гүйдлээс хамгаалсан тоноглолтой байна. Халуун хөшигнүүдийг тэжээлийн кабель зэс голтой уян кабель байна./180 м КГ-10х4 марк / - Цахилгааны кабелиудыг барилгын ханыг цоолж сүвлэх ба хамгаалалтын ган хоолой хийж сүвлэнэ.
<p>11. Бусад</p>	<ul style="list-style-type: none"> - Одоо байгаа нам даралтын халаалтын зуухны холболт салгаж гаргах, утааны төмөр яндан буулгах. - Нийт 30м² халаалтын зуухны өрөөний засварын ажлыг бүрэн хийж

	<p>гүйцэтгэх.Бетон шаланд тэгшилгээ хийж хулдаас дэвсэх, тааз шохойдох, хана будах</p> <ul style="list-style-type: none">- Гадна дээвэрт гарсан утааны яндангын нүхийг битүүлж бороо ус орохгүй болгон засварлах.- Гадна хаалга 1ш /1200 х 2100мм/ гадна цонх 1ш /1450х1450мм/ шинээр солих.- Тавигдах бүх тоног төхөөрөмж, сэлбэг материал нь урьд өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байна
--	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|-------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
10. **Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. **Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
12. **Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
13. **Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. **Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15. **Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. **Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх** 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>“Уурхайн захиргааны барилгад халаалтын зуух усрах, халуун хөшиг тавих ажлыг” ЭТТ/201901009</i>
ГЕН 2.1	Ажил нь <i>“Уурхайн захиргааны барилгыг дулаанаар хангах, засварын газрын заалны хаалганд халуун хөшиг тавих ажлаас”</i> бүрдэнэ. Ажлын талбай нь Өмнөговь аймаг Цогтцэций сум болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь <i>[томилогдсон этгээдийн нэр, хаяг]</i>
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр <i>[огноо]</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[огноо]</i> ⁴
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[7]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа <i>[1]</i> жил байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувь байна. ⁵ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>50 хувиас хэтрэхгүй</i> байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -иар тооцно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

⁵ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

_____ (Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ___-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ___ дугаар сарын ___-ны өдөр эхэлж, _____ оны ___ дугаар сарын ___-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;

- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]